


ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

03.30 - 04.03



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: АНУ-ын томоохон индексүүд өнгөрсөн долоо хоногт уналттай хаагдсан бөгөөд сарын болон улирлын өөрчлөлт 2008 оноос хойш байгаагүй муу дүнтэй байгаа юм.

S&P500 индексийн сагсанд багтах эрчим хүчний салбарын компаниудын хувьцаа газрын тосны үнийг даган өсөлттэй хаагдсан байна. Пүрэв гарагт АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп, Саудын Араб болон ОХУ-ыг газрын тосны үйлдвэрлэлээ танана гэсэн хүлээлттэй байгаагаа олон нийтэд мэдэгдсэн нь газрын тосны үнийг огцом өсөхөд нөлөөлсөн байна. Урт хугацаат бондын өгөөжийн хувь буурсан нь хүүгийн түвшинд мэдрэг салбарууд болох санхүүгийн болон үл хөдлөх хөрөнгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын ханшид нөлөөлсөн байна. Коронавирусын эдийн засагт үзүүлж буй нөлөөлөл нь хөдөлмөрийн зах зээл дээр бодитоор харагдаж байна. Өнгөрсөн долоо хоногт шинээр 6.6 сая Америкчууд ажилгүйдлийн тэтгэмжид бүртгүүлэхээр хүсэлт гаргасан бөгөөд ажилгүйдлийн түвшин 4.4% болж өссөн нь 2017 оноос хойш байгаагүй өндөр үзүүлэлт болж байна.

Европ: Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд өнгөрсөн долоо хоногт өөрчлөлт багатай байсан ба шинээр зарлагдсан эдийн засгийн үзүүлэлтүүдээс харахад коронавирүсээс болж энэ жил эдийн засаг уналтад орох нь тодорхой болж байна. STOXX Europe 600 индекс 0.45%, ХБНГУ-ын DAX индекс 1%, Франц улсын CAC 40 индекс 4.26%, Итали улсын FTSE MIB индекс 1.75% тус тус унасан байна. Английн фунтийн ханш чанга байгаа нь экспортлогчдод дарамт учруулж, Их Британийн FTSE 100 индекс 1.3% унахад нөлөөлсөн байна.

Английн Төв Банкнаас арилжааны банкнууд, энгийн болон давхар даатгалын компаниудад коронавирүс хямралыг давж гарахын тулд ногдол ашиг тараах болон хувьцаа халааслах үйл ажиллагаагаа зогсоох санал тавьснаар даатгалын болон банкны салбаруудын хувьцааны ханш буурахад нөлөөлсөн байна.

Япон: Японы хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай хаагдлаа. Nikkei 225 индекс 8.1% (буюу 1,569 пунктээр) унаж 17,820.19 хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 24.7%-аар бага байгаа юм. TOPIX Large-сар болон Small индексүүд 2020 он эхэлснээс хойш харгалзан 23.0%, 28.2% унаад байна. Баасан гарагийн байдлаар иений ам.доллартой харьцах ханш 108 байгаа юм. Коронавирүс цар тахалт, АНУ болон БНХАУ-ын худалдааны дайнаас үүдсэн нийлүүлэлтийн доголдоос болж Японы компаниудын орлого буурах төлөвтэй байна. Хамгийн сүүлийн үеийн таамаглалаар 1.3 их наяд иен буюу 12 тэрбум ам.долларын алдагдал хүлээхээр байна.

БНХАУ: БНХАУ-ын 3-р сарын PMI индекс таамаглалаас өндөр гарсан болон Хятадын Ардын Банкны бодлогын хүү ба зайлшгүй байлгах нөөцийн хэмжээг бууруулах шийдвэрүүд нь өнгөрсөн долоо хоногт үнэт цаасны зах зээл харьцангуй тогтвортой байхад нөлөөлжээ. Shanghai Composite индекс, CSI 300 индексүүд бага зэргийн (0.6%) уналттай хаагдсан байна. 3-р сарын 27-нд болсон БНХАУ-ын удирдагчдын долоо хоног тутмын Politburo-гийн уулзалтаар эдийн засгийг тогтворжуулах сангийн дэмжлэгүүдийг хэрэгжүүлэхээр болж, 2020 онд ихээхэн хэмжээний төсвийн алдагдал хүлээхээр болжээ.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	16,911.09	-1.46% ▼
Dow Jones	АНУ	21,052.53	-2.70% ▼
S&P 500	АНУ	2,488.65	-2.08% ▼
Nasdaq	АНУ	7,373.08	-1.72% ▼
S&P/TSX	Канад	12,938.30	1.97% ▲
FTSE 100	Их Британи	5,415.50	-1.72% ▼
S&P/ASX 200	Австрали	5,067.50	4.65% ▲
Nikkei 225	Япон	17,820.19	-8.09% ▼
Hang Seng	Хонг Конг	23,280.06	-0.87% ▼

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	96.16
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	90.49
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	90.78
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	99.69
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	102.33
DBM' 2023	USD	7.250%	89.75
TDBM' 2020	USD	9.375%	98.72
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	79.26

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.985	0.00 ▼
Libor 3M	1.387	-0.06 ▼
Libor 6M	1.209	0.14 ▲
Libor 1YR	1.050	0.08 ▲
US 2YR Bond	0.237	0.00 ▼
US 3YR Bond	0.310	0.03 ▲
US 5YR Bond	0.402	0.02 ▲
US 10YR Bond	0.625	-0.02 ▼

Валютын ханш	2020.04.03	Өөрчлөлт
USD	2,779.78	0.16% ▲
CNY	391.86	0.08% ▲
EUR	3,001.19	-1.95% ▼
RUB	36.02	0.92% ▲
KRW	2.26	-0.88% ▼
JPY	25.69	0.71% ▲
CAD	1,962.98	-0.69% ▼

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,620.81	-0.45% ▼
Мөнгө /спот/	USD/t oz.	14.39	-0.55% ▼
Зэс	USD/lb.	219.25	0.94% ▲
Нүүрс	USD/MT	63.82	-9.71% ▼
WTI газрын тос	USD/bbl.	28.34	31.75% ▲
Brent газрын тос	USD/bbl.	34.11	36.82% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020. II	6.4%
Бодлогын хүү	2020. II	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020. II	10.95 %
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020. II	11.33%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020. II	4.71%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020. II	17.01%
Зээлийн дундаж хүү /валют/	2020. II	10.35%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 50 компанийн 835.9 сая төгрөгийн 2,534,086 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Монноос” /MNS/ компанийн хувьцаа 14.87%-аар буюу хамгийн ихээр өсөж 2,240.00 төгрөг хүрч хаагдсан бол “Шарын гол” /SHG/ компанийн хувьцаа 14.51%-аар буурч 1,025.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.


04-р сарын 03-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,478.7 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 16,911.09 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.81%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2020 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн тойм

Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)
Арилжигдсан үнийн дүн	835.9
Зах зээлийн үнэлгээ	2,478,662.4

Зах зээлийн индексүүд

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	16,911.09	-1.81% ▼
MSE I индекс	7,836.91	-1.08% ▼
MSE II индекс	7,581.52	-0.52% ▼

Идэвхтэй арилжагдсан хувьцаа

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Ард санхүүгийн нэгдэл	346,687	522,645,327
АПУ	96,897	50,319,908
Монгол алт	8,754	48,147,000
Мандал даатгал	773,576	34,932,146
Ард кредит ББСБ	336,404	25,055,069

Өсөлттэй хувьцаа

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Монноос	2,240.00	14.87% ▲
Хай би ойл	62.99	14.53% ▲
УБ-БҮК	450.00	13.64% ▲
Хөх ган	79.50	13.57% ▲
Фронттиер лэнд групп	340.00	13.33% ▲

Бууралттай хувьцаа

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Шарын гол	1,025.00	-14.51% ▼
Мон-ит булигаар	6,300.00	-12.50% ▼
Их барилга	2,290.00	-11.92% ▼
Хөвсгөл алтан дуулга	580.01	-10.77% ▼
Адуун чулуун	1,031.00	-6.10% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)
Ард Секюритиз	1,095,269,609
Дархан Брокер	96,294,000
БиДиСек	94,790,458
Стандарт Инвестмент	75,007,542
Голомт Капитал	53,560,138

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	ЗЗҮ (сая.төг)
АПУ	531.00	565,080
Таван толгой	5,440.00	286,499
МИК Холдинг	11,910.00	246,648
Инвескор ББСБ	2,490.00	178,603
Говь	180.00	140,420

Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТ ХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	NA	2020.08.31-НИЙ ДОТОР
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	NA	2020.06.30-НЫ ДОТОР
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-НЫ ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-НЫ ӨДӨР
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.30-НЫ ДОТОР
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	715.9	1,000.0	139.7%	35.0	2020.04.07	2020.04.30-НЫ ДОТОР
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	NA	2020.06.24-НЫ ӨДӨР
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-НЫ ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	NA	2020.06.30-НЫ ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.04.24-ӨӨС
11	BUK	УЛААНБААТАР БҮК	2,465.3	526.2	21.3%	4.0	NA	2020.06.01-ЭЭС
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	NA	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХҮНС	761.9	408.9	53.7%	1.0	NA	2020.08.31-НИЙ ДОТОР
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-НЫ ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	NA	2020.05.01-ЭЭС
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.03.15-ААС
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	NA	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.06.30-НЫ ДОТОР
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	NA	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-НИЙ ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	NA	2020.06.30-НЫ ДОТОР
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	NA	2020.05.01-НИЙ ДОТОР
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.05.01-ААС 2020.05.15-НЫ ХООРОНД
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-НЫ ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	NA	2020.08.01-НЫ ДОТОР
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	NA	2020.06.01-ЭЭС
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	NA	2020.05.01-ЭЭС

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ



Санхүүгийн Зохицуулах Хорооны 2020 оны 01-р сарын 29-ний өдрийн 29-р тогтоолоор Үнэт цаасны дараа төлбөр тооцооны Т+2 горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлт зарчмыг 2020 оны 3-р сарын 31-ний өдрөөс эхлэн нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн байна. Үнэт цаасны дараа төлбөр тооцооны Т+2 горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлт зарчим нэвтэрснээр зах зээлд оролцогчдын арилжааны шимтгэл, зардал буурч, зах зээлийн хөрвөх чадвар сайжрах, гадаад дотоодын хөрөнгө оруулагчид үнэт цаасны арилжаанд оролцоход таатай нөхцөл бүрдэх зэрэг эерэг нөлөөтэй юм.

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

“Ган хийц” ХК-ийн ТУЗ ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэжээ

Монголын Хөрөнгийн биржийн II ангилалд бүртгэлтэй “Ган хийц” ХК 2019 онд 240.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан тул энэ жил ногдол ашиг тараахгүй гэж ТУЗ нь шийдвэрлэжээ.

Эх сурвалж: BloombergTV.mn

“Мах импекс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал цахим хэлбэрээр зохион байгуулагдана

Улсын онцгой комиссын 2020 оны 03-р сарын 20-ны шийдвэр, Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан зөвлөмжийн дагуу “Мах Импекс” ХК нь 2020 оны 04-р сарын 24-ний өдрийн 14 цагаас хуралдах хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлуудад цахимаар санал хураахаар шийдвэрлэсэн байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Монос хүнс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Монос Хүнс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 04-р сарын 06-ны өдрийн 14 цагаас хуралдахаар төвлөсөн байсан боловч COVID-19 вирусийн тархалттай холбоотойгоор ээлжит хурлын товыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан байна.

Цаашид вирусийн тархалт хэзээ багасах нь тодорхойгүй байгаа тул ээлжит хурлыг цахимаар явуулах тухай СЗХ-ны уриалгыг “Монос Хүнс” ХК-ийн зүгээс дэмжин хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахимаар явуулах бэлтгэл ажлыг эхлүүлээд байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Говь” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал цахим хэлбэрээр зохион байгуулагдана

“Говь” ХК нь Ковид-19 вирусийн халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахимаар явуулах тухай СЗХ-ны уриалга чиглэлийн дагуу 2020 оны 04-р сарын 24-ний өдрийн 10 цагаас хуралдах хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахимаар явуулахаар шийдвэрлэсэн байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Талх чихэр” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал цахим хэлбэрээр зохион байгуулагдана

“Талх Чихэр” ХК нь Ковид-19 вирусийн халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахимаар явуулах тухай СЗХ-ны уриалга чиглэлийн дагуу 2020 оны 04-р сарын 20-ны өдрийн 14 цагаас хуралдах хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахимаар явуулахаар шийдвэрлэсэн байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Монгол базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал цахим хэлбэрээр зохион байгуулагдана

“Монгол базальт” ХК нь Ковид-19 вирусийн халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахимаар явуулах тухай СЗХ-ны уриалга чиглэлийн дагуу 2020 оны 04-р сарын 03-ны өдрийн 15 цагаас хуралдах хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахимаар явуулахаар шийдвэрлэсэн байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

03-р сард Монгол Улсын борлуулалтын менежерүүдийн индекс 30-аас доош нэгжид хүрч унасныг "World Economics" мэдээллээ.

Энэ нь тус судалгааг гаргаж эхэлснээс хойших хамгийн тааруу үзүүлэлт болжээ. Мөн бизнесийн итгэлийн индекс судалгааг танилцуулснаас хойших түүхэн доод нэгжид хүрсэн байна. Түүнчлэн борлуулалтын өсөлт сүүлийн таван жилийн доод нэгжид хүрчээ. Ингэснээр эдийн засгийн идэвх сүүлийн долоон жилийн тааруу үзүүлэлттэй байгааг "World Economics" тайландаа онцлов.

Эх сурвалж: BloombergTV.mn



МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Монголбанк, Сангийн яам, Монголын ипотекийн корпорац болон банкнууд хамтран орон сууцны Төрөөс хэрэгжүүлж буй ипотекийн найм болон таван хувийн хүүтэй зээл авсан иргэн зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулах хүсэлт гаргасан тохиолдолд зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг нэг удаа гурав хүртэлх сараар хойшлуулж, тухайн хугацаагаар зээлийн эргэн төлөлтийн хуваарийг уртасгахаар шийдвэрлэжээ.

Энэ хүрээнд зээлийн эргэн төлөлтөд нь 2020 оны 01-р сарын 31-ний өдрөөс хойш доголдол үүссэн зээлдэгчид энэхүү зохицуулалт үйлчлэх боломжтой бөгөөд доголдол үүссэн хуваарьт өдрөөс эхлэн эргэн төлөлтийг хойшлуулах хугацааг тооцох юм байна.

Эх сурвалж: BloombergTV.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

I улиралд Монгол Улс 3.1 сая тонн чулуун нүүрс экспортолсон нь 2019 оны мөн үеэс 59.8%-аар буурсан байна. Мөнгөн дүнгээр 39%-аар буурч, 250.6 сая ам.доллар боллоо.

Одоогийн байдлаар нүүрсний экспорт сэргэж, Гашуунсухайт, Шивээхүрэн, Замын-Үүд, Хангийн боомтоор нүүрс экспортолж байна. Хэдий тийм боловч хэмжээний хувьд ердийн үеэс бага байна.

Эх сурвалж: BloombergTV.mn



МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.